

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 7648 дугаарт бүртгээв

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН “ГҮНИЙ-УС” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн “Гүний-Ус” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Гүний-Ус” ХХК /Ц.Бадралтхүү/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Гүний-Ус” ХХК /Ц.Бадралтхүү/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 78, 2020 оны 107, 2021 оны 125 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 91 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН “ГҮНИЙ-УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	тоолууртай	төг/л	2.20
	тоолуургүй	төг/л	2.80
	Ус түгээх байр	төг/л	2.72
Бохир ус	тоолууртай	төг/л	2.20
	тоолуургүй	төг/л	2.80

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	6.30
	Төсөвт байгууллага	төг/л	7.50
	Спирт, архи пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр авто машин угаалга	төг/л	6.30
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	6.30
	Зөөврөөр	төг/л	7.00
Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	7.28
	төсөвт байгууллага	төг/л	8.50
	Спирт, архи пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр авто машин угаалга	төг/л	7.28
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	7.28
	Зөөврөөр	төг/л	12.60

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 07-ны өдрийн
91 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН “ГҮНИЙ-УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

БУЛГАН АЙМГИЙН “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн “Булган мээж” ОНӨХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Булган мээж” ОНӨХХК /О.Далайцэрэн/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Булган мээж” ОНӨХХК /О.Далайцэрэн/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2021 оны 65 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 07-ны
өдрийн 92 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**БУЛГАН АЙМГИЙН “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	3.00
	Тоолуургүй	төг/л	3.80
	Ус түгээх байр	төг/л	2.73
Бохир ус	Тоолууртай	төг/л	3.50
	Тоолуургүй	төг/л	4.00

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	9.00
	Төсөвт байгууллага	төг/л	12.00
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	12.00
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	9.00
	Төсөвт байгууллага	төг/л	12.00
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	12.00
	Зөөврөөр	төг/л	18.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 07-ны өдрийн
92 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**БУЛГАН АЙМГИЙН “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 7650 дугаарт бүртгэв

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ДАРХАН УС СУВАГ” ХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, ажиллахыг “Дархан ус суваг” ХК /С.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Дархан ус суваг” ХК /С.Ганзориг/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 116 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2021 оны 54 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт, Зохицуулах хорооны 2023 оны 110, 2024 оны 48 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 93 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ДАРХАН УС СУВАГ” ХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.56
	Тоолуургүй	төг/л	3.43
	Ус түгээх байр /зөөвөр/	төг/л	2.73
Бохир ус	Тоолууртай	төг/л	2.73
	Тоолуургүй	төг/л	3.78

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	ҮААНБ /тоолууртай/	төг/л	4.97
	Төсөвт байгууллага /тоолууртай/	төг/л	5.36
	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	төг/л	5.36
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр /тоолууртай/	төг/л	5.17
Бохир ус	ҮААНБ /тоолууртай/	төг/л	5.36
	Төсөвт байгууллага /тоолууртай/	төг/л	5.78
	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	төг/л	5.78
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр /тоолууртай/	төг/л	5.57

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 07-ны өдрийн
93 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ДАРХАН УС СУВАГ” ХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймгийн “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хөвсгөл ус суваг” ХХК /Ч.Батсүх/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Хөвсгөл ус суваг” ХХК /Ч.Батсүх/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 28, 2020 оны 72, 2021 оны 61 дүгээр тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 07-ны
өдрийн 94 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	3.00
	Тоолуургүй	төг/л	3.20
Бохир ус	Тоолууртай	төг/л	3.80
	Тоолуургүй	төг/л	4.20

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	4.00
	Төсөвт байгууллага	төг/л	4.00
	ҮААНБ зөөврөөр	төг/л	13.10
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	5.80
	Төсөвт байгууллага	төг/л	5.80
	Зөөврөөр	төг/л	12.50

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 07-ны өдрийн
94 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

БАЯНХОНГОР АЙМГИЙН “ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн “Чандмань Баянхонгор” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Чандмань Баянхонгор” ХХК /Б.Соронзонбаатар/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Чандмань Баянхонгор” ХХК/Б.Соронзонбаатар/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 70, 2021 оны 48 дүгээр тогтоол, Зохицуулах хорооны 2024 оны 53 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 95 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН “ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.8
	Тоолуургүй	төг/л	3.0
	Ус түгээх байр	төг/л	4.0
Бохир ус	Тоолууртай	төг/л	2.8
	Тоолуургүй	төг/л	3.00

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	5.0
	Төсөвт байгууллага	төг/л	10.0
	Спирт, архи пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр автомашин угаалга	төг/л	10.0
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	8.0
	Зөөврөөр	төг/л	15.0
Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	3.5
	төсөвт байгууллага	төг/л	8.0
	Спирт, архи пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр автомашин угаалга	төг/л	8.5
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	7.5
	Зөөврөөр	төг/л	40.0

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 07-ны өдрийн
95 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**БАЯНХОНГОР АЙМГИЙН “ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 13/20

Хутаг-Өндөр
сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 64 дугаар зүйлийн 64.1, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан үнэ тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас хураан барагдуулж орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж, зохих журмын дагуу зарцуулж, тайланг гаргаж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Ууганбаяр)-д даалгасугай.

3.Үйлчилгээний хураамжийн хэмжээг захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд холбогдох журмын дагуу бүртгүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Отгонсайхан)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Батлагдсан шийдвэрийг иргэд, аж ахуй нэгжид мэдээлэл хүргэн сурталчилж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн (Б.Гантуяа)-д даалгасугай.

6.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Отгонсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БААСАНЦЭРЭН

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 6 дугаар сарын 29 -ний
өдрийн 13/20 дугаар тогтоолын хавсралт*

**ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХУРААМЖ**

Д/д	Хог хаягдал гаргах эх үүсвэр	Сар тутмын татвар хураамж
1.	Хутаг-Өндөр сумын Хутаг 1-р баг, Хантай, Уньт, Тээл, Хонгор багуудын айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамж	4000 төг
2.	Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчийн үйлчилгээний газар (м²)	1 м²-30 м² 3000 төг
		31 м²-50 м² 4500 төг
		51 м²-70 м² 6500 төг
		71 м²-90 м² 8500 төг
		91 м²- 100 м² дээш 10000 төг
3.	Төсвийн байгууллага	100 м² дээш 20000 төг
		1-10 ажилтантай 4000 төг
		11-20 ажилтантай 6000 төг
		21-40 ажилтантай 8000 төг
		41-дээш ажилтантай 10000 төг
4.	Аж ахуйн нэгж	1-5 ажилтантай 4000 төг
		6-10 ажилтантай 6000 төг
		11-20 ажилтантай 8000 төг
		21-дээш ажилтантай 10000 төг
5.	Халаалтын зуух (ажилласан сараар)	Нэгдсэн халаалтын зуух 50000 төг
		Нам даралтын зуух 3000 төг
6.	Аялал жуулчлалын бааз, амралт сувилалын газар	1-20 ортой 5000 төг
		21-45 ортой 8000 төг
		46-60 ортой 20000 төг
		61-80 ортой 25000 төг
		81-100 ортой 30000 төг
		101-дээш ортой 35000 төг

БУЛГАН АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар Х/52

Баяннуур сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.5, 41.6 дахь хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 192, А/243 дугаар хамтарсан тушаалыг тус тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн ээлжит X хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Суманд төрийн байгууллага, аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгч, иргэдээс сар бүр авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Сумын Засаг дарга (Б.Ёндон)-нд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн татварын орлогод сар бүр жигд төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Батхуяг)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны IY/03 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

М.ДОРЖПҮРЭВ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 6 дугаар сарын 29 -ний
өдрийн Х/52 дугаар тогтоолын хавсралт*

**ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧ ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгчдийн нэрс	Төлбөр төлөх сарын тоо	Сард төлөх төлбөр /Төг-өөр/
1	Иргэн	12	450
2	Албан байгууллага	12	15000
3	Аж ахуй нэгж	12	10000
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	12	5000

ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ
1	Кама ачааны машин 3тн	70000
2	Поошиг	5000

БУЛГАН АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 20

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Тэшиг сумын “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлэн 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхийг “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ /Б.Мөнгөнсүх/-т үүрэг болгосугай.

3.Тус тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2024 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний
зохицуулах зөвлөлийн 2026 оны
20 дугаар тогтоолын хавсралт*

**БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ СУМЫН “ТЭШИГ-УС” ОНӨААТҮГ-
ЫН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Булган аймгийн “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Тэшиг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	2196,3
		төг/гДж	43006
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	900
		төг/гДж	15235
4	Айл өрх	төг/м ²	720
		төг/гДж	3575

БУЛГАН АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 21

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 02/46 дугаар албан бичгээр ирсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Бугат сумын “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлэн 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхийг “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний
зохицуулах зөвлөлийн 2026 оны
21 дүгээр тогтоолын хавсралт*

**БУГАТ СУМЫН “ДОЛООН БАР” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

6.Булган аймгийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Бугат сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	2063,8
		төг/гДж	41980,4
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	1400
		төг/гДж	20210
4	Айл өрх	төг/м ²	950
		төг/гДж	4310

БУЛГАН АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 22

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 02/46 дугаар албан бичгээр ирсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Сэлэнгэ сумын “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлэн 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхийг “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 04 дугаар тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний
зохицуулах зөвлөлийн 2026 оны
22 дугаар тогтоолын хавсралт*

**СЭЛЭНГЭ СУМЫН “ДОЛООН БАР” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

2.Булган аймгийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Сэлэнгэ сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	2176,3
		төг/гДж	42988
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	1400
		төг/гДж	20210
4	Айл өрх	төг/м ²	950
		төг/гДж	4310

БУЛГАН АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 24

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 02/46 дугаар албан бичгээр ирсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Хангал сумын “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлэн 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхийг “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний
зохицуулах зөвлөлийн 2026 оны
24 дүгээр тогтоолын хавсралт*

**ХАНГАЛ СУМЫН “ДОЛООН БАР” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

3.Булган аймгийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Хангал сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	2089,2
		төг/гДж	42031
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	1400
		төг/гДж	20210
4	Айл өрх	төг/м ²	950
		төг/гДж	4310

БУЛГАН АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 26

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 02/46 дугаар албан бичгээр ирсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Орхон сумын “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлэн 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхийг “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний
зохицуулах зөвлөлийн 2026 оны
26 дугаар тогтоолын хавсралт*

**ОРХОН СУМЫН “ДОЛООН БАР” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

5.Булган аймгийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Орхон сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	2278,7
		төг/гДж	43977
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	1400
		төг/гДж	20210
4	Айл өрх	төг/м ²	950
		төг/гДж	4310

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар А/169

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам”-д доор дурдсан агуулга бүхий 3.5.1, 3.5.2, 3.10, 3.11, 4.3 дахь заалтуудыг нэмсүгэй.

“3.5.1. 0.22 кВ-ын хүчдэлийн түвшинд холбогдох нарны цахилгаан үүсгүүрийн суурилагдсан хүчин чадал 12 кВт-аас ихгүй байна.”

“3.5.2. 0.4 кВ-ын хүчдэлийн түвшинд холбогдох хэрэглэгч нь зөвхөн 0.4 кВ-ын гаралтын хүчдэлтэй инвертер ашиглана.”

“3.10 Хуулийн этгээдийн түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ нь өөрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 30 хувиас хэтрэхгүй байна.”

“3.11 Суурилагдсан хүчин чадал нь 1,500 кВт-аас дээш сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах этгээд нь Эрчим хүчний тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авсан байна.”

“4.3 Түгээх сүлжээнд 1,500 кВт-аас дээш суурилагдсан хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг холбохдоо холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу улсын комисс ажиллуулж ашиглалтад оруулна.”

2.Мөн журмын 1.3 дахь заалтад “1,500 кВт гэснийг 9,000 кВт”, 3.5 дахь заалтад “10 кВ гэснийг 35 кВ” гэж тус тус өөрчилсүгэй.

САЙД

Б.НАЙДАЛАА

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар А/109

Улаанбаатар
хот

ТУШААЛ, ЗААВАРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Заавар батлах тухай” Хууль зүйн сайд (хуучин нэрээр)-ын 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/90 дүгээр тушаалын үндэслэх хэсгийн “41.12” гэснийг “41.13” гэж, мөн тушаалын 1 дэх заалтын “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэний” гэж, мөн тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар”-ын нэрийг “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар” гэж, мөн зааврын 1.1 дэх хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэний хяналтын” гэж, 2.1, 2.3 дахь хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын газар” гэж, 5.2, 5.4.7, 5.4.8 дахь заалтын “Аюулгүй байдлын хэлтсийн” гэснийг “Захиргаа, удирдлагын газрын” гэж, 2.6 дахь хэсгийн “Аюулгүй байдлын хэлтэс” гэснийг “Захиргаа, удирдлагын газар” гэж, 2.7 дахь хэсгийн “Аюулгүй байдлын хэлтэст” гэснийг “Захиргаа, удирдлагын газарт” гэж, 5.4.8 дахь заалтын “Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан дэд даргад” гэснийг “Гадаадын иргэн харьяатын газрын даргад” гэж, 1.1, 4.1 дэх хэсгийн “41.9” гэснийг “41.10” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Мөн зааврын 2.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.4. Харьяалах нэгжийн дарга болон Гадаадын иргэний хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчид тусгай хэрэгслийг хүлээлгэн өгч, буцаан авах бөгөөд гарын үсэг зуруулан бүртгэл хөтөлнө.”

3. Мөн зааврын 2.6 дахь хэсгийн “Аюулгүй байдлын хэлтэс” гэснийг хассугай.

4. Мөн зааврын 8.2 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

5.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямбад даалгасугай.

САЙД

С.АМАРСАЙХАН

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авсан*

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар А/150

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам батлах тухай” Сангийн сайдын 2017 оны 249 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САЙД

З.МЭНДСАЙХАН

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнтэй холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2026 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1/2056 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Журам батлах тухай” (Хилийн цэсийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлт) Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хүчингүй болсон захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасалт хийлгэх ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраад үүрэг болгосугай.

САЙД

Э.БАТ-АМГАЛАН

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авсан

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар А/118

Улаанбаатар
хот

ТУШААЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТУШААЛЫН ХАВСРАЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Тушаал, тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/67, А/201 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам, загвар батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/267 дугаар тушаалын 1 дэх хэсгийн ““Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосныг хүлээн зөвшөөрсөн маягтын загвар”-ыг зургаадугаар” гэснийг хассугай.

2. Мөн тушаалын зургаадугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.АМАРСАЙХАН

